

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ  
ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалах чиглэлээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгагдаж, эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй байх үеийн хугацааг алба хаасан хугацаанд оруулан тооцох, цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгохтой холбоотой болон цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч ажлаас чөлөөлөгдвэл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгохоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд улсын төсвөөс нэмэлт зардал гарагчийг гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим сайгад байршуулж олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон хүүхэд харах чөлөөний хугацааны төсвийг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсэн болон хүүхэд харах чөлөөтэй байх үеийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд хэрхэн зохицуулж ирсэн, тэдгээр хүмүүсийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, төсөлд тусгагдсан цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч ажлаас чөлөөлөгдвэл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгох заалтын хүрээнд жилд хэдэн хүн хамрагдаж хэдэн төгрөгийн төсөв зарцуулагдах талаар, өмнө нь олгож ирсэн цэргийн цолны зөрүүг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бodoх заалт нь эрх зүйн орчныг дордуулах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хуулийн төслийн хамрах хүрээнд Төрийн цэргийн бүх байгууллага орж байгаа

талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулиар олгогдсон жирэмсний болон амаржсаны дараах нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ажиллаж байх хугацааны үндсэн цалин хөлснөөс тооцдог бөгөөд түүнээс хойш хүүхдээ 3 нас хүртэл харах тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгохыг ялгах, 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох заалтыг Төрийн албаны хуультай нийцүүлэн ажилласан жилтэй нь дүйцүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Ахмад настны тухай хуульд заасан насанд хүрээгүй байхдаа нас барсан тохиолдолд түүнд оршуулгын зардал олгодоггүй хуулийн хийдэл байгааг хэрхэн зохицуулах талаар, цэргийн анги, салбарт ажиллаж байгаа энгийн алба хаагчдын эрх зүйн байдлын талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлээгүй бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

ТУС3761 9001061209 9067154